



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ¹

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

Эрх зүйн үндэслэл

Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 195 дугаар зүйлд Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлахаар тусгасан бөгөөд нотариатчийг хуульч байхаар тогтоох, нотариатын цахим үйлдэл, нотариатын акт үйлдэх зэрэг шинэ төрлийн үйл ажиллагааг зохицуулахыг заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.6.9-д “Хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тууштай хамгаалж, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлж, иргэний бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна ...” хэмээн заасан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.4-т “Нотариатын байгууллагатай харилцах болон төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах” зэргийг тусгажээ.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Нотариатын тухай хууль /цаашид “НтХ” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх захиалга ирүүлсэнтэй холбогдуулан энэхүү судалгааг гүйцэтгэв.

Практик үндэслэл

НтХ холбогдох харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг үр дагаврыг илрүүлэх нь хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шалтгааны нэг болно.

Монгол Улсын нутаг дэвсгэр өргөн уудам, хүн амын нягтаршил сийрэг байдгаас шалтгаалан хөдөө, орон нутгийн зарим алслагдмал бүсэд нотариатын үйлчилгээг зохих журмын дагуу эрх авсан этгээд буюу нотариатч бус өөр субъект /засаг дарга/ үзүүлэх тохиолдол байсаар байна.

Мөн нотариатын үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр түдгэлзүүлэх зохицуулалт үйлчилж байгаа нь тусгай зөвшөөрөл бүхий этгээд удаан хугацаагаар өөр ажил эрхлэх, улмаар иргэдэд үзүүлэх нотариатын үйлчилгээний хүртээмж багасах, эрх зүйн үйлчилгээ авах эрх нь хязгаарлагдахад хүргэдэг.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд аргачлалын 3.2.1-д “тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байвал”, 3.2.2-т “...зайлшгүй зохицуулах харилцааг зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс шалтгаалан сөрөг үр дагаварт бий болсон бол”, 3.2.3-д “захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол” гэсэн нөхцөлүүд хангагдаж байгаа тул НтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага байна гэж үзлээ.

Иймд дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг харгалзан Засгийн газрын 2017 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ,

¹ Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Б.Гончигсумлаа, Х.Ариунсүрэн нар хамтран гүйцэтгэв.

шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримтлан уг судалгааг гүйцэтгэхээр төлөвлөв.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Судалгааг гүйцэтгэхдээ хуулийн бүхий л зүйл, заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх нь үнэлгээний ач холбогдлыг бууруулах магадлалтай байдаг. Өөрөөр хэлбэл хэлбэрийн төдий, тулгамдсан асуудалгүй зохицуулалт бүрт үнэлгээ хийснээр судалгааны хүрээ хэт өргөн, судалгааны объект тодорхойгүй, нуршуу болох нь тохиолддог.

Иймд НтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, тулгамдаж буй асуудалд холбогдох дараах зохицуулалтыг сонгон авч үнэлгээний хүрээг тогтоов. Үүнд:

1. Нотариатын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүрээнд

НтХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно:

17.1.1.энэ хуульд заасан нотариатын үйлдэл хийх журмыг зөрчсөн нь тогтоогдсон бол 3 сар хүртэл хугацаагаар;

17.1.2.нотариатч эрүүгийн хариуцлагад татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн эцсийн шийдвэр гартал;

17.1.3.энэ хуулийн 21.2, 21.3, 22.1, 24.1-д заасныг зөрчсөн бол 6 сар хүртэл хугацаагаар;

17.1.4.нотариатч төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон тохиолдолд тухайн шийдвэрийг нь үндэслэн.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

2. Цахим нотариатын үйлчилгээг хөгжүүлэх асуудлын хүрээнд

НтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6. Танхим нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нотариатын үйл ажиллагаатай холбогдсон бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлж ажиллах бөгөөд хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээ, мэдээлэл, тайлан, тоо баримтыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай үнэ төлбөргүй солилцож, харилцан мэдээлнэ.

3. Нотариатчид тавигдах шаардлагын хүрээнд

НтХ-ийн 6 дугаар зүйл. Нотариатчид тавих шаардлага:

6.1.Дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нотариатын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй:

6.1.3.нотариатын үйлдэл хийх ажлын байртай.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдал, сонгон авсан зохицуулалтын онцлог зэргийг харгалзан үнэлгээний аргачлалын 3.4-т заасан 6 шалгуур үзүүлэлтээс “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгон авлаа.

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд НтХ-ийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлно. Сонгосон зохицуулалтыг практикт нийцсэн байдлыг

шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл зөвлөмж, санал боловсруулна.

1.4. Үнэлгээний арга зүй

Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан гүйцэтгэв. Ингэхдээ баримт бичиг судлах, харьцуулах, ярилцлагын арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг тус тус ашиглав.

1.5. Судлагдсан байдал

Судлагдсан байдлын хувьд нотариатын салбар бусад салбар эрх зүйгээс харьцангуй бага судлагдсан гэж хэлж болох ба судалгааны эх сурвалж мөн цөөн байдаг. Тэдгээрээс дурдвал, Д.Долгорсүрэн “Нотариат: Түүхэн практик, үйл ажиллагаа” УБ.,2005 номондоо нотариатын тухай ойлголт, нотариатын үйлдлийг авч үзэхийн зэрэгцээ нотариатын үйл ажиллагааг түүхэн баримтад тулгуурлан судалсан.

Ч.Баянжаргал “Нотариат” УБ.,2005 он бүтээлдээ нотариатын онолын үндэс, нотариатын байгууллагын тогтолцоо, нотариатын үйл ажиллагааны талаар авч үзсэн байна. Мөн тэрээр “Нотариатын байгууллагын менежмент” УБ.,2009 он бүтээлдээ нотариатын байгууллагын удирдлагын үйл ажиллагаанд менежментийн шинжлэх ухааны үүднээс хандаж, түүний онол, практикийн туршлагад тулгуурлан байгууллагын эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлон, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал дэвшүүлжээ.

Монголын Нотариатчдын танхим, МУИС-ийн Хууль зүйн сургууль хамтран 2010 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Нотариатын эрх зүйн орчин, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд нотариатын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санаачилга болон шинээр өргөн баригдаад буй НтХ-ийн төсөлтэй холбоотой онол, практикийн асуудлыг хөндсөн байна.

Мөн А.Оюунчимэг “Нотариатын үйлдэл: Мэргэжлийн аргачилсан зөвлөмж” УБ.,2007 он бүтээл зэргийг тус тус туурвиж байжээ.

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үе шатанд НтХ-иас сонгосон зохицуулалтад шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийв.

1.1. Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1

Хуулийн 17 дугаар зүйлд заасан нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхтэй холбогдох зохицуулалт практикт хэр нийцсэн бэ?

Нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхэд хугацаа тогтоож өгөөгүйтэй холбогдон үүсэж буй бэрхшээлийг зохицуулах хүрээнд шалгуур үзүүлэлтийн томьёолол 1-ийг боловсруулав.

17 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

17.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно:

17.1.1. Энэ хуульд заасан нотариатын үйлдэл хийх журмыг зөрчсөн нь тогтоогдсон бол 3 сар хүртэл хугацаагаар;

17.1.2. Нотариатч эрүүгийн хариуцлагад татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн эцсийн шийдвэр гартал;

17.1.3. Энэ хуулийн 21.2, 21.3, 22.1, 24.1-д заасныг зөрчсөн бол 6 сар хүртэл хугацаагаар;

17.1.4. Нотариатч төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон тохиолдолд тухайн шийдвэрийг нь үндэслэн.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан түдгэлзүүлэх үндэслэл арилсан тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

НтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан шаардлагыг хангасан иргэнд Мэргэшлийн хорооны саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоор заасан. Тусгай зөвшөөрөл авсан этгээд нотариатын үйлчилгээ явуулах бөгөөд хуульд заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөл байдал тогтоогдсоноор хүчингүй болгосон, эсхүл эрх бүхий этгээд нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсны улмаас нотариатын үйл ажиллагаа явуулах эрх дуусгавар болдог.

НтХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “нотариатч төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон тохиолдолд тухайн шийдвэрийг нь үндэслэн” нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээр заасан. Энэхүү зохицуулалт нь мэргэшсэн нотариатчийн нөөцийг тогтвортой хадгалах эерэг талтай байж болох ч практикт нотариатаар ажиллахаас илүүтэй тусгай зөвшөөрлөө түдгэлзүүлэн өөр төрлийн ажил эрхлэх хандлагыг нэмэгдүүлсээр байна. Энэхүү байдал “нотариатын ажлыг төрийн албаны дараа оруулан ойлгох зэрэглэлийг бий болгож байна” гэх шүүмжлэлийг дагуулж байгаа юм. Цаашид дээрх шүүмжлэлд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

НтХ-д тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг ерөнхий зохицуулсан, үүнд тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр түдгэлзүүлсэн байдаг нь нэг талаас иргэдийн нотариатын үйлчилгээ авах эрх зөрчигдөх, нөгөө талаас нотариатаар ажиллах сонирхол бүхий бусад этгээдийн боломжийг хаах нөхцөлийг бүрдүүлж байна.²

Хууль зүйн сайдын 2015 оны А/202 дугаартай тушаалаар нотариатчийн ажиллах тойрог, орон тоог шинэчлэн тогтоохдоо 66 тойрогт, 317 нотариатч ажиллахаар заасан.³


2017 онд боловсруулсан НтХ-ийн төслийн үзэл баримтлалын төсөлд 27 нотариатч тусгай зөвшөөрлөө түдгэлзүүлсэн болон бусад шалтгаанаар үйл ажиллагаагаа хэвийн явуулахгүй байгаа талаар дурджээ. Харин 2018 онд нийт 15 нотариатч тусгай зөвшөөрлөө түдгэлзүүлсэн байдалтай байна.⁴

² Нотариатын тухай хуулийн төрслийн үзэл баримтлалын төсөл. 2018 он. 2 дахь тал.

³ Нотариатын тойрог, орон тоог хавсралт 1-д дэлгэрэнгүй үзүүлэв.

⁴ Монголын Нотариатчдын танхимын 2018.03.23-ны өдрийн №209 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээ.

Нотариатчдын орон тооны талаарх мэдээлэл /2018 оны байдлаар/



Нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх зохицуулалтыг НтХ-д бүрэн тусгаж чадаагүй гэж болно. Үүнийг тайлбарлавал НтХ-д нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хугацаагүй түдгэлзүүлж болохоор зохицуулсан. Иймд дээрх тусгай зөвшөөрлийг удаан хугацаагаар түдгэлзүүлэн өөр ажил эрхлэх тохиолдол түгээмэл байдаг. Практик дээр ихэвчлэн төрийн албан тушаалд томилогдон олон жил ажилласны дараа халагдахаараа, эсхүл тэтгэвэрт гарахаараа нотариатын үйл ажиллагаагаа эрхэлдэг. Иймд энэ байдлыг даруй зогсоох нь зүйтэй бөгөөд нотариатын ажлын нэр хүнд, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

Чингэлтэй дүүргийн нотариат

Сүхбаатар дүүргийн нотариаттай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс.

Дээр дурдсанаас үзэхэд нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг “төрийн албан тушаалд томилогдсон” гэх үндэслэлээр хугацаагүй түдгэлзүүлэх нь практикт оновчгүй зохицуулалт байж болохоор байна. Иймд шаардлагатай гэж үзвэл богино хугацаанд түдгэлзүүлэн, урт хугацаанд түдгэлзүүлэхгүйгээр хүчингүй болгох зохицуулалтыг хэрэглэх нь тохиромжтой байна.

Нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхдээ ямар ч тохиолдолд хугацаагүйгээр түдгэлзүүлэх нь зохимжгүй бөгөөд үйлчилгээ авч буй иргэн, энэ төрлийн үйлчилгээ эрхлэх сонирхол бүхий бусад этгээдийн эрхийг зөрчиж байна гэж үзэж болно.

1.2. Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2

Хуулийн 17 дугаар зүйл практикт хэр нийцсэн бэ?

Цахим нотариатын үйл ажиллагааг нэвтрүүлэх, дэмжих хүрээнд шалгуур үзүүлэлтийн томъёолол 2-ийг боловсруулав.

8 дугаар зүйл. Нотариатын байгууллагын бүтэц, зохион байгуулалт.

8.6. Танхим нь нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нотариатын үйл ажиллагаатай холбогдсон бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлж ажиллах бөгөөд хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээ, мэдээлэл, тайлан, тоо баримтыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай үнэ төлбөргүй солилцож, харилцан мэдээлнэ.

Цахим нотариатын үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, гэрээ болон гэрлэлт цуцлалт, үрчлэлт гэх мэт эрх зүйн үйлдлийг нотариатаар гэрчилсэн баримт бичиг нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулах үндэслэл, бүртгэл үнэн зөв байх баталгаа болдог. Баримт бичгийг нотариатаар баталгаажуулахын ач холбогдол өндөр боловч орчин цагт түүнийг уламжлалт байдлаар хэрэгжүүлэх нь иргэд, албан байгууллагад хүндрэл дагуулах болжээ.

Иргэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ гэрээ, хэлцэл, өв залгамжлал, гэрлэсэн эсэх зэрэг холбогдох мэдээллээ өөрийн биеэр цуглуулдаг бөгөөд нотариатаар баталгаажуулсны дараа хувийг төрийн байгууллагад хүргэж өгдөг. Дээрх байдал нь иргэдэд олон дахин явах, цаг алдах, нэмэлт зардал гарах, байгууллагад ажлыг ачаалал үүсэх зэрэг шалтгаан болдог байна.

Засгийн газрын цахим бодлогын хүрээнд болон Улсын бүртгэлийн багц хууль батлагдсантай холбогдуулан нотариатын үйлчилгээг уялдуулах, нотариатын үйлчилгээнд цахим нотариатын системийг бий болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Цахим нотариатыг нэвтрүүлснээр дараах эерэг үр дүн гарах боломжтойг “Цахим нотариат” хэлэлцүүлэг дээр онцолсон байна. Үүнд⁵:

Төрд

- Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, үйлчилгээ чанартай, түргэн шуурхай, найдвартай, чирэгдэлгүй болох;
- Төрийн мэдээллийн цахим нэгдсэн сан сайжрах;
- Төрийн албан хаагчдын ажлын бүтээмж нэмэгдэх;
- Далд эдийн засгийн орлого ил болж татварын орлого нэмэгдэх;
- Шүүхийн ачаалал буурах, нотлох баримт цуглуулахад хялбар болох;
- Эрх зүйн үйлчилгээ боловсронгуй баталгаатай болох;
- Бусад.

Иргэнд

- Нотариатын үйлчилгээ хялбар, хурдан шуурхай, чирэгдэлгүй, орон зайнаас хамааралгүй байх;
- Төрийн бүх үйлчилгээг хялбар, хурдан, найдвартай авах;
- Цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт гаргах;
- Эрх зүйн ухамсар дээшлэх;
- Бусад.

Нийгэмд

- Иргэдийн өмчлөх эрх баталгаатай хамгаалагдах;
- Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа хөгжлийн шинэ түвшинд гарах;
- Хууль бус үйлдэл буурах;
- Бусад.

НтХ 2011 онд батлагдсанаас хойш тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн зохицуулалт бүрэн агуулгаараа хэрэгжээгүй байна. Уг зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд Монголын нотариатчдын танхимын Ерөнхийлөгчийн тушаалаар нотариатын байгууллага цахим системд шилжих бэлтгэл ажлыг хангах “Цахим нотариат” ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийг 2017 онд шинэчлэн 20 хүний бүрэлдэхүүнтэй болгож өргөжүүлсэн.

Монголын нотариатчдын танхимаас “Цахим нотариатын эрх зүйн орчныг бүрдүүлэхээр Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт холбогдох санал өгөх зэргээр ажилласан байна.⁶

“Цахим нотариат” ажлын хэсэг үйл ажиллагааныхаа хүрээнд Үндэсний Дата төв УТҮГ, Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар болон төрийн байгууллагуудтай хамтарсан уулзалтууд зохион байгуулахын зэрэгцээ “Цахим

⁵ “Цахим нотариат” хэлэлцүүлэг. 2015.01.30-ны өдөр. <http://news.gogo.mn/r/155350>. Сүүлд үзсэн: 2018.08.30.

⁶ Монголын Нотариатчдын танхимын 2016 онд хийсэн ажлын тайлан. 16 дахь тал.

нотариат” төслийн програм хангамжийн ажил гүйцэтгэх” техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, захиалгаар программ бүтээх ажлыг эхлүүлсэн байна.

Одоогоор програмын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа талаар Монголын Нотариатчдын танхимын 2017 онд хийсэн ажлын тайланд тусгажээ.⁷

Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангана”, 14.2 дахь хэсэгт “Цахим мэдээллийн сан дахь мэдээллийг хуулбарлан, технологийн дагуу хадгална.”, 12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэгт “Лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр олгож болно.” хэмээн тус тус зохицуулсан байна.

Нотариатын болон бусад байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан нотариатын үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор нотариатын үйлдлийг цахимжуулах, улсын бүртгэлийн болон бусад холбогдох байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах, баяжуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага үүсэж байна.⁸ Иймд цахим нотариатын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд НтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн зохицуулалтыг нарийвчлах, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай юм.

1.3. Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3

Хуулийн 6 дугаар зүйл практикт хэр нийцсэн бэ?

Нотариатчид тавих шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд шалгуур үзүүлэлтийн томьёолол 2-ийг боловсруулав.

НтХ-ийн 6 дугаар зүйл. Нотариатчид тавих шаардлага
 6.1. Дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нотариатын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй:
 6.1.3. нотариатын үйлдэл хийх ажлын байртай.

НтХ-ийн 6 дугаар зүйлд нотариатчид тавих шаардлагыг мэргэшлийн шалгалтад тэнцсэн, ял шийтгэлгүй, нотариатын үйлдэл хийх ажлын байртай байхаар заасан. Гэвч энэхүү шаардлагыг хангалттай бус, одоогийн шалгуурыг өндөрсгөх, хуульд нийцүүлэх, нотариатч хуульч мэргэжилтэй байх шаардлагатай талаар салбарын мэргэжилтнүүд онцолдог.

НтХ-иар Нотариатч нь үндсэн болон тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан. Нотариатч төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцаанд оролцож байгаа этгээдэд эрх зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэг,⁹ нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр, үл маргах шинжтэй болох үйлдэл, баримт бичгийг гэрчлэх, үйлчлүүлэгч хүсвэл нотариатаар гэрчлүүлэхээр хуульд зааснаас бусад үйлдэл, баримт бичгийг үл маргах шинжтэй болгох зорилгоор гэрчлэх, гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх, хууль зүйн агуулга бүхий үйлдэл, баримт бичгийг хуульд заасан тохиолдолд болон шүүх, төрийн бусад байгууллагын хүсэлтээр гэрчлэх болон хуульд заасан бусад үүргийг тодорхой чиг үүрэг¹⁰ хамаарахаар хуульчилжээ. Дээрхээс үзэхэд нотариатчийн үйл ажиллагаа нь талуудын эрх, ашиг сонирхлыг хамгаалан эрх зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн гэрээ, хэлцлийг гэрчлэх зэрэг мэргэшсэн хуульч гүйцэтгэвэл зохих чиг үүргийг гүйцэтгэж байна.

⁷ Монголын Нотариатчдын танхимын 2017 онд хийсэн ажлын тайлан. 21 дэх тал.

⁸ Нотариатын тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл.

⁹ НтХ. 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг.

¹⁰ НтХ. 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд Хуульчийн эрхлэх мэргэжлийн үйл ажиллагааны төрөлд “хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх” үүргийг хуульчилсан нь нотариатын үйл ажиллагааг хуульч эрхлэх нь тохиромжтой болохыг харуулж байна.

1997 онд батлагдсан НтХ-иар Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэн тусгай зөвшөөрөл авахаар мэргэшлийн шалгалт өгөх эрхтэй байсныг 2011 онд баталсан НтХ-иар өөрчилж заавал хуульчийн гэрчилгээтэй байх шаардлагыг хассан юм. Гэвч бусад хууль тогтоомжид нотариатчийг хуульч байхыг шаардсан зохицуулалт байсаар байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д “Хуульчдын их хурлын төлөөлөгчдийн 40 хувь нь өмгөөлөгч, 40 хувь нь шүүгч, прокурор, 20 хувь нь бусад хуульчдын төлөөлөл байх”-аар заасан ба бусад хуульчдын төлөөлөлд нотариатыг багтаан ойлгож байна. Үүнээс шалтгаалан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болон эрхгүй нотариатч хэмээх ойлголтоор ангилан авч үзэхэд хүргэж байна.

Нотариатын үйл ажиллагаа бол яахын аргагүй маш чухал, өндөр хариуцлага шаардсан ажил байдаг. Нотариатчид ямагт эрх зүйн үр дагавар өөрчлөгдөж болохуйц харилцаанд орж эрх зүйн баримт бичгийг гэрчилдэг. Иймээс нотариатын үйл ажиллагааг хууль, эрх зүйн өндөр мэдлэгтэй этгээд эрхлэх нь зүйтэй. Өндөр мэргэжилтэй гэдгийг харилцан ялгаатай тайлбарлах боломжтой. Тиймээс хамгийн зөв хувилбар бол хуульчийн мэргэшлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй буюу хуульчийн эрхтэй этгээд нотариатын үйл ажиллагаа эрхлэх зүйтэй гэж үздэг.

*Монголын Нотариатчдын танхимын ерөнхийлөгчтэй
хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Иймд нотариатын гүйцэтгэх чиг үүргийн онцлогийг харгалзан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй этгээд нотариатын үйл ажиллагаа эрхлэх тухай зохицуулалтыг НтХ-д тусгах шаардлагатай байна.

Мөн нотариатын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд ажлын байртай байх шаардлага тавигддаг. Энэ нь шинээр мэргэшлийн шалгалт өгөх гэж байгаа иргэдэд хүндрэл учруулдаг бөгөөд бүрдүүлбэрийг хангахын тулд дүр үзүүлсэн баримт бичиг бүрдүүлэхэд хүргэдэг байна.

НтХ-иар нотариатчид тавигдах шаардлагад нотариатын үйлдэл хийх ажлын байртай байхыг шаарддаг. Нотариатын үйл ажиллагаа явуулах эрх авах нь өрсөлдөөн өндөртэй шалгаруулалт болдог. Нотариатын сонгон шалгаруулалтын тухайд нийслэлд гэхэд л нэг ажлын байран дээр 50-70 хүн шалгалт өгдөг бөгөөд эдгээр хүмүүс бүгд хуульд заасны дагуу нотариатын үйлдэл хийх ажлын байраа бэлдсэн байх боломжгүй юм. Энэ байдлыг ч ойлгон 2015 онд ХЗДХЯ-аас шалгалтыг зарлахдаа 6.1.3-д заасан шаардлагыг тавиагүй.

Сүхбаатар дүүргийн нотариатч

Тиймээс шалгалтанд бүртгүүлэгчдэд ХЗДХЯ-аас дээрх шаардлагыг тавьдаггүй байна.

Нотариатчийн чиг үүргийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн гүйцэтгэж, нотариатын үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажиллаж байгаа иргэнийг нотариатч хэмээн хуульд тодорхойлсон байна. НтХ-ийн 6 дугаар зүйлд “Дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нотариатын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй” гэж тодорхой заасан нь энэ чиг үүргийг гүйцэтгэх этгээд дурдсан шаардлагыг зайлшгүй хангасан байхыг онцолсон.

Гэвч НтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Нотариатч ажиллаагүй суманд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан сумын Засаг даргын Тамгын газрын дарга нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэнэ.”,

16.3 дахь хэсэгт “Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газарт хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс эрх авсан албан тушаалтан нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэнэ” гэж заасан нь нотариатын гүйцэтгэх чиг үүргийг хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй, мэргэшсэн шалтгалт өгөөгүй этгээд эрхэлж болохоор зохицуулжээ.

Нөгөө талаас алслагдмал байршилтай хөдөө орон нутагт иргэд нотариатын үйлчилгээ авах нь цөөн байдаг тул уг үйлчилгээ нь өөрийгөө санхүүжүүлэн тогтвортой үйл ажиллагаагаа явуулж чаддаггүй. Иймд нотариатчдын зүгээс орлого багатай алслагдмал хөдөө орон нутагт ажиллах нь хүндрэлтэй байдаг байна. Иймээс дээрх нөхцөл байдлыг давхар харгалзан үзэх шаардлагатай.

1.4. Монголын Нотариатчдын танхимын эрх зүйн байдал, түүний Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүн

Монголын Нотариатчдын танхимын эрх зүйн байдал

Монголын Нотариатчдын танхим нь НтХ-д заасны дагуу Нотариатчдыг эгнээндээ нэгтгэсэн, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу уялдуулан зохицуулах, эрх ашгийг нь хамгаалах зорилготой байгууллага юм. Тус байгууллага нь гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллагын статустай байхаар дүрэмдээ заасан байна.¹¹

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэгт “гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага” гэж өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдэгээс бусад төрийн бус байгууллагыг тодорхойлжээ. Нотариатчдын танхим гишүүнчлэлээрээ дамжуулан нийгмийн харилцаанд чухал үүргийг гүйцэтгэдэг тул зөвхөн “гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага” гэж тодорхойлох нь түүний ач холбогдлыг бууруулсан байж болохоор байна. Нотариатчдын танхимыг Улсын их хурлын тогтоолоор байгуулсан, Нотариатын үйлдэл хийх зааврыг батлах, нотариатын үйлдэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар шийдвэрлэдэг зэргээс үзэхэд уг байгууллага нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн шинжийг агуулж байна.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн шинжийг авч үзвэл нийтийн зорилгыг хэрэгжүүлэхээр нийтийн эрх зүйн хууль тогтоомжид тулгуурлан зохион байгуулагддаг бөгөөд тэдгээрт төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн өмчийн байгууллагууд буюу улсын сургууль, сүм, хийд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч бусад байгууллагууд буюу улсын радио, телевизийн газар зэргийг ойлгож болно.¹²

Нотариатын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт Нотариатчдын танхимийн үндсэн чиг үүргийг тодорхойлсон¹³ бөгөөд Монголын Нотариатчдын танхимын дүрмийн 6 дугаар зүйлд “Нотариатчдын танхим нь нотариатчдыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, тэдгээрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, төрийн болон төрийн бус байгууллагад төлөөлөх, нотариатчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тус дэмжлэг үзүүлэх, гишүүдийн сар тутмын үйлдэл, орлогын мэдээ гаргалт, татвар

¹¹ Монголын Нотариатчдын танхимын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг. Монголын Нотариатчдын танхим нь мэргэшлийн нотариатчдыг эгнээндээ нэгтгэсэн гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.

¹² Хуулийн этгээдийн төрөл ба тэдгээрт оноосон нэр, томъёоны тухай. <http://advocate.mn/news/119/single/774>. Сүүлд үзсэн: 2018.08.31-ний өдөр.

¹³ НтХ. 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг. Нотариатчдыг эгнээндээ нэгтгэсэн, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг энэ хууль болон өөрийн дүрэмд заасны дагуу уялдуулан зохицуулах, эрх ашгийг нь хамгаалах зорилготой Монголын Нотариатчдын танхим /цаашид “Танхим” гэх/ ажиллана.

төлөлт, нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж байгаа эсэхэд хяналт тавихад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.” хэмээн нарийвчлан зохицуулжээ. Дээрх чиг үүргээс дүгнэн үзэхэд Монголын Нотариатчдын танхим нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн статустай байх нь тохиромжтой байна.

Монголын Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөл

Нотариатын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт Монголын нотариатчдын танхимын дэргэд Сахилгын /цаашид “Сахилгын зөвлөл” гэх/ болон Хяналтын зөвлөл ажиллах бөгөөд тэдгээрийн эрх хэмжээг Танхимын дүрмээр тогтоохоор заасан. Сахилгын зөвлөл нь нотариатчдын үйл ажиллагаанд хяналт тавих, Нотариатын тухай хууль, Монголын Нотариатчдын танхимын дүрэм, Монголын Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн дүрэм, Нотариатчийн ёс зүйн дүрэм, Монголын Нотариатчдын танхимын гишүүн нотариатчаас иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлага, нотариатчийн үйл ажиллагаандаа баримталбал зохих бусад хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж нотариатчид сахилгын шийтгэл оногдуулах эсэх асуудлыг хянан шийдвэрлэх эрх бүхий үүрэгтэй орон тооны бус зөвлөл юм.¹⁴

Монголын Нотариатчдын танхимын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт “Сахилгын зөвлөлийг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр нотариатчдын танхимын бүх гишүүдийн хурлаас сонгож байгуулна” гэж заасан бол 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Сахилгын зөвлөлд ажлын туршлагатай, хамт олны итгэл хүлээсэн нотариатчийг нэр дэвшүүлж бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүдийн олонхийн санал авсан нотариатчийг сонгоно” хэмээн тодорхойлжээ. Дээрх зохицуулалтаас нотариатчдын ёс зүй, сахилгын асуудлыг шийдвэрлэж буй сахилгын хорооны гишүүн нь нотариатч байхаар тодорхойлсныг харж болно.

Дээрх зохицуулалтаас шалтгаалан дараах 2 асуудал нэн түрүүнд хөндөх болсон байна. Үүнд:

1. Нотариатчийн үйл ажиллагаанд хяналт тавих, сахилгын шийтгэл оногдуулах эсэх асуудлыг адил статустай өөр нотариатчид хэрэгжүүлэх болсон

Сахилгын зөвлөлийн гишүүд нотариатч мэргэжилтэй байгаа нь асуудлыг хэт туйлшруулах, нэгэн хэвийн байдлаар хандах, зөрчил гаргасан этгээдэд хөнгөн хариуцлага хүлээлгэх гэх мэт ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргаж болзошгүй хэмээн судлаачид үздэг.

2. Сахилгын зөвлөл өөрөө өөрийнхөө асуудлыг шийдвэрлэх болсон.

Сахилгын зөвлөлийн гишүүн нотариатч сахилгын зөрчил гаргасан бол түүнийг зөвлөл хэрхэн шийдвэрлэх талаар хууль тогтоомжид тодорхой тусгаагүй байна. Гэхдээ энэхүү нөхцөлийг шийдвэрлэхдээ Монголын Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн дүрмийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Нотариатчид холбогдох сахилгын хэргийг Сахилгын зөвлөлийн гишүүдийн ердийн олонхийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ” гэх заалтыг хэрэглэх замаар бусад гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэх төлөвтэй байна. Дээрхээс үзэхэд Сахилгын зөвлөл гишүүнийхээ асуудлыг өөрөө шийдвэрлэхээр байгаа нь зөвлөлд итгэх, түүний хараат бус, бие даасан байх зарчим алдагдахад нөлөөлөх боломжтой байна.

Орчин үед Сахилгын хороо нэг төрлийн статустай гишүүдээс бүрдэх загвараас татгалзаж тухайн салбарын боловч өөр байгууллагуудын төлөөлөл, эрдэмтэн судлаачдыг багтаах хандлагатай болсон бөгөөд Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийн явцад зарим салбарт нэвтрээд байна. Үүнээс жишээ болгон дурдвал Шүүхийн сахилгын хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг дурдаж болно.

¹⁴ Монголын Нотариатчдын танхимын дүрэм, 12 дахь хэсэг.

Академич Ж.Амарсанаа “Шүүгчийн ёс зүй” бүтээлдээ “Ардчилсан нийгэмд шүүх эрх мэдлийг бусад эрх мэдэлтэй харилцан тэнцвэржүүлж, хянаж шалгаж чаддаг тогтолцоо байх хэрэгтэй бөгөөд үүний нэг хэсэг нь өөр өөр субъектээс нэр дэвшүүлж байгуулсан Сахилгын хороо юм.” хэмээн тэмдэглэсэн байдаг. Шүүхээс өөр байгууллагаас шүүгчийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүний олонхыг нэр дэвшүүлэх нь шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний шаардлагад иргэдийн тавих хяналтыг бий болгосон шинэлэг зохицуулалт болсон¹⁵ бөгөөд шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахад чухал нөлөөтэйг харуулж байна.

Дээрх дурдсаныг харгалзан Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүнд нотариатчдаас гадна бусад хөндлөнгийн байгууллагын төлөөллийг оруулахад анхаарч гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй байна.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Дүгнэлт

2011 онд шинэчлэн баталсан НтХ-ийн үзэл санаа, зохицуулалт орчин үеийн чиг хандлагад нийцсэн, нотариатын эрх зүйн харилцааг боломжит түвшинд сайн зохицуулсан гэж салбарын мэргэжилтнүүд үздэг байна.

Үнэлгээний явцад тус хуульд бүхэлд нь эерэг үнэлгээ өгч болох ч практик дээр нотариатчид тавих шаардлага, цахим нотариат, нотариатын үйл ажиллагаа эрхлэх этгээд, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаа зэрэг зохицуулалтаас шалтгаалсан хүндрэл байсаар байна.

Иймд тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ дээр дурдсан асуудлын хүрээнд “практикт нийцсэн байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээг гүйцэтгэж дараах дүгнэлтэд хүрэв.

Хуулийн 17 дугаар зүйлд заасан нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхтэй холбогдох зохицуулалт практикт хэр нийцсэн бэ?

Хуулийн 17 дахь хэсэгт заасны дагуу нотариатч төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон тохиолдолд нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх явдал нь нотариатын үйлчилгээ хүртээмжтэй байхад сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. Иймд дээрх шалтгаан бий болсон тохиолдолд түдгэлзүүлэх бус тусгай зөвшөөрлийг цуцлах нь илүү оновчтой байж болох юм. Нөгөө талаас НтХ-д тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр түдгэлзүүлэхээр заасан нь нотариат нотариатын үйл ажиллагаа эрхлэхгүйгээр хойш тавих, өөр ажил эрхлэх нийтлэг тохиолдол гардаг байна. Энэ нь иргэдийн нотариатын үйлчилгээ авах эрхийг хөндөөд зогсохгүй нотариатчийн ажлын нэр хүндийг бууруулж байна.

Цахим нотариатын үйл ажиллагааг нэвтрүүлэх, дэмжих хүрээнд НтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг практикт хэр нийцсэн бэ?

НтХ 2011 онд батлагдсанаас хойш 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг хэрэгжээгүй гэж хэлж болохоор байна. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монголын Нотариатчдын танхимаас нотариатын байгууллага цахим системд шилжих бэлтгэл ажлыг хангах “Цахим нотариат” ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд программ бичилтийн ажил 80 хувьтай байна.

Засгийн газраас төрийн захиргааны байгууллагын бүртгэлийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангаж ажиллах хүрээнд Улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалттай уялдуулан авч үзэх шаардлагатай.

¹⁵ Л.Бямбаа. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний шаардлага, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал”, 37 дахь тал.

Нотариатчид тавигдах шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэх хүрээнд хуулийн 6 дугаар зүйл практикт хэр нийцсэн бэ?

Нотариатч нь иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн гэрээ, хэлцлийг гэрчлэх чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд түүний үйлдлээс бий болох эрх зүйн үр дагавар өндөр байдаг. Иймд нотариатын үйл ажиллагааг эрх зүйч мэргэжилтэй этгээд эрхлэх шаардлагатай бөгөөд тэр дундаа мэргэшсэн хуульч байх нь тохиромжтой байна. Гэвч нотариатчийн гүйцэтгэх чиг үүрэг, мэргэшлийн шалгалтын өгөгдлөөс хамааран эрх зүйч мэргэжилтэй иргэд нотариатын сонгон шалгаруулалтад орох нь түгээмэл байна.

Мөн хуульд нотариатын үйлдэл хийх ажлын байртай этгээд нотариатын үйл ажиллагаа эрхлэхээр зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн иргэн бүр ажлын байртай байх шаардлага тавигдахаар байгаа нь хүсэлт гаргагч нарт бэрхшээл үүсгэх талтай.

3.2. Зөвлөмж

Нотариатын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд тулгуурлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах зөвлөмж, саналыг гаргаж байна. Үүнд:

- Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй түдгэлзүүлдэг өнөөгийн зохицуулалтыг өөрчлөн хугацаатай түдгэлзүүлэх зохицуулалтыг хуульд тусгах;
- Нотариатч төрийн албан тушаалд томилогдсон, сонгогдсон тохиолдолд нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, эсхүл богино хугацаатай түдгэлзүүлэх бөгөөд энэ хугацаа хэтэрсэн тохиолдолд хүчингүй болгох зохицуулалтыг хуульд тусгах;
- Нотариатын үйлчилгээг цахим болгохтой холбогдуулан улсын бүртгэлийн байгууллага болон бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах;
- Нотариатчид тавигдах шалгуурыг өндөрсгөх, нотариатын үйл үйлдэл эрхэлж буй этгээд нь мэргэшсэн хуульч байх;
- НТХ-иар Нотариатын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэнд нотариатын үйлдэл хийх ажлын байртай байхыг шаардаж буй өнөөгийн зохицуулалтыг анхаарч, тусгай зөвшөөрлөө авсны дараа ажлын байрыг шаардах гэх мэт уян хатан зохицуулалтыг тусгах;
- Нотариатч биш боловч нотариатын үүргийг гүйцэтгэх этгээдийн талаар авч үзэх, хуулийн уялдаа холбоог сайжруулах
- Монголын Нотариатчдын танхимын эрх зүйн байдлыг тодорхой болгох, Нийтийн эрх зүйн хуулийн этгээд байхаар тодорхойлох
- Монголын Нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, хөндлөгийн байгууллагын төлөөллийг оролцуулах замаар зөвлөлийн хараат бус, бие даасан байдлыг дээшлүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1992 оны №1;
2. Нотариатын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2011 оны №9;
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2002 оны №8;
4. Нотариатын үйлдэл хийх журам, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 171 дүгээр тушаалын хавсралт;
5. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл. Улсын Их Хурлын 2017 оны №12 тогтоолын хавсралт;
6. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Улсын Их Хурлын 2016 оны №45 тогтоолын хавсралт;
7. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө. Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралт;
8. Нотариатын тухай хуулийн үзэл баримтлалын төсөл. 2017 он
9. Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2017 он.

Нэг сэдэвт бүтээл, судалгаа

10. Монголын Нотариатчдын танхим. Нотариатын эрх зүйн орчин хөгжлийн чиг хандлага. Эмхэтгэл. УБ.,2010;
11. Ч.Баянжаргал. Нотариатын байгууллагын менежмент. УБ.,2009;
12. Ч.Баянжаргал. Нотариат. УБ.,2005;

НОТАРИАТЫН ТОЙРОГ, ОРОН ТОО

